


БАТЛАВ
"ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ" ТӨҮГ

ЗАХИРАЛ



Г.ГАНСҮХ

АВТОМАШИН ХУДАЛДАХ,
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2019.03.26

№2019/042

Улаанбаатар хот

Энэхүү Автомашин худалдах, худалдан авах гэрээ (цаашид "гэрээ" гэх)-г нэг талаас "УАЗ МЕГА" ХХК, түүнийг төлөөлж захирал Д.Мягмарсүрэн (цаашид "Худалдагч" гэх), нөгөө талаас "ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ" ТӨҮГ, түүнийг төлөөлж Ерөнхий нягтлан бодогч Б.Дэлгэрдалай (цаашид "Худалдан авагч" гэх) нар (хамтад нь "Талууд" гэх) Монгол Улсын Иргэний хуулийн 243-264 дүгээр зүйлийг тус тус үндэслэн харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Гэрээгээр худалдагч нь худалдан авагчид гэрээнд заасан тоноглол, техникийн нөхцөл, өнгө, загварын шинэ автомашин (цаашид "автомашин" гэх)-ийг нийлүүлэх, худалдан авагч автомашиныг хүлээн авч, үнийг гэрээнд заасны дагуу төлөх үүргийг тус тус хүлээнэ.

1.2 Гэрээнд талууд тэгш эрхтэй оролцсон бөгөөд гэрээний бүх зүйл заалттай бүрэн танилцаж, хүлээн зөвшөөрч, хүсэл зорилгоо бүрэн илэрхийлсэн болно.

1.3 Гэрээ нь дараах хавсралттай байх ба хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

- Хавсралт №1-д автомашины стандарт тоноглол, техникийн үзүүлэлт, өнгө, загварыг заана.
- Загвар: УАЗ ФУРГОН 2018 он
- Өнгө: Цагаан / саарал


1.4 Автомашины өмчлөх эрх үнийг бүрэн төлсөн нөхцөлд худалдан авагчид шилжинэ.

Хоёр. Автомашины үнэ, төлбөр хийх нөхцөл


2.1 Автомашин нь 31,000,000 (гучин нэгэн сая) төгрөг үнэтэй байна. Энэ үнэд гэрээний зүйлийн бүх өртөг зардал (үүнд: гааль, НӨАТ, гаалийн бүрдүүлэлтийн хураамж, худалдан авагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх төрлийн тээврийн, хадгалалтын болон бусад зардал) багтсан болно.

2.2 Автомашины төлбөрийг зөвхөн Худалдагчийн банкны харилцах дансанд шилжүүлсэн, үүнийгээ нотолсон баримтыг худалдагч талд хүлээлгэн өгсөн, эсхүл худалдагч талын касст бэлнээр тушаасан тохиолдолд төлбөр гүйцэтгэсэн гэж тооцно.

Гурав. Талуудын эрх, үүрэг


..... /Б.Дэлгэрдалай/

1 of 3


..... /Д.Мягмарсүрэн/

3.1 Худалдан авагчийн эрх, үүрэг.

3.1.1 Энэ гэрээний Хавсралт №1-д заасан стандарт тоноглол, өнгө, загвар бүхий автомашиныг тохиролцсон хугацаанд нийлүүлэхийг худалдагчаас шаардах эрхтэй.

3.1.2 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Худалдагчаас шаардах эрхтэй.

3.1.3 Худалдан авагч аль ч үед автомашины чанар, техникийн талаар худалдагчаас үнэн зөв, бүрэн мэдээлэл гаргуулан авах эрхтэй.

3.1.4 Гэрээний Хавсралт №1-д зааснаас өөр автомашиныг хүлээн авахаас татгалзах эрхтэй.

3.1.5 Худалдан авагч нь энэхүү гэрээний 2.2-т заасан хугацаанд автомашины төлбөрийг барагдуулах үүрэгтэй.

3.1.6 Худалдан авагч нь автомашины үзүүлэлт, нэмэлт тоноглолыг захиалгад нийцэж байгааг шалган, худалдагчтай автомашин хүлээлцсэн акт үйлдэн хүлээн авна.

3.1.7 Автомашиныг актаар хүлээн авсанаас хойш автомашины бүрэн бүтэн байдлыг худалдан авагч бүрэн хариуцна.

3.1.8 Худалдан авагч тал автомашины баталгаат засварын хугацаанд буюу 1 жилийн туршид зөв зохистой, зориулалтаар нь ашиглах үүрэгтэй.

3.1.9 Худалдан авагч нь автомашины улсын дугаар, гэрчилгээ авах, түүнтэй холбогдон төлөх албан татвар, болон үзлэг оношлогооны зардал, хариуцлагын даатгал зэргийг хийлгэхтэй холбогдон гарах бүх зардал, төлбөрийг хариуцна.

3.1.10 Худалдан авагч нь автомашиныг хүлээн авсанаас хойш нэр шилжүүлээгүйтэй холбогдон үүсэх аливаа хариуцлагыг өөрөө хүлээнэ.

3.2 Худалдагчийн эрх, үүрэг

3.2.1 Худалдан авагчаас гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

3.2.2 Гэрээний Хавсралт №1-д заасан техникийн үндсэн үзүүлэлт стандарт ба нэмэлт тоноглол өнгө, загвар бүхий биет байдлын болон эрхийн доголдолгүй автомашиныг худалдан авагчид хүлээлгэн өгнө.

3.2.3 Худалдан авагчид автомашиныг хүлээлгэн өгсөн өдрөөс хойших автомашины үйлдвэрлэлийн бус эвдрэл, гэмтэл, устаж үгүй болсонтой холбогдсон хариуцлагыг худалдагч хүлээхгүй.

3.2.4 Төлбөрийг бүрэн барагдуулсан тохиолдолд автомашиныг худалдагчийн өмчлөлд шилжүүлж, түүнтэй холбоотой гаалийн болон бусад баримт бичгийг хүлээлгэн өгнө.

3.2.5 Худалдагч нь баталгаат засварын 6 сар ба 12,000 км-ийн аль түрүүлж дуусах хугацааны туршид үйлдвэрлэлийн доголдол, согог гарсан тохиолдолд үнэ төлбөргүй засварлаж, шинэчилж өгөх үүрэгтэй.

Дөрөв. Автомашиныг шилжүүлэн өгөх

4.1 Автомашиныг хүлээлгэн өгөх, хүлээн авахдаа стандарт тоноглол, техникийн үндсэн үзүүлэлтийг захиалгад нийцэж байгаа эсэхийг шалгаж, Автомашин хүлээлцсэн акт үйлдэн, талууд зөвшөөрч гарын үсэг зурж, хүлээн авснаар эзэмших, ашиглах эрх худалдан авагчид шилжинэ.

Тав. Гэрээний хариуцлага, гэрээг цуцлах үндэслэл

5.1 Талууд энэ гэрээгээр хүлээсэн үүргээ гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас автомашинд хохирол учирсан тохиолдолд автомашин худалдан авагчийн эзэмшилд шилжихээс өмнө худалдагчид, шилжсэнээс хойш худалдан авагч эрсдлийг хүлээнэ.

5.2 Худалдан авагчийн буруутай үйл ажиллагааны улмаас худалдагчид учирсан хохирол, зардлыг худалдан авагч хариуцна.

Зургаа. Бусад зүйл

6.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, гэрээний үүргийн гүйцэтгэл бүрэн биелэгдсэнээр гэрээ дуусгавар болно.

6.2 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэн талуудад хадгалагдах бөгөөд эдгээр нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.


6.3 Энэхүү гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжийг үндэслэн хийгдсэн бөгөөд түүний дагуу зохицуулагдана. Хуульд өөрөөр заагаагүй бол гэрээний зүйл заалтыг нэн тэргүүнд баримтлана.

6.4 Энэ гэрээтэй холбоотой саналын зөрүүтэй асуудлыг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба ийнхүү шийдвэрт хүрээгүй нөхцөлд хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


"ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ
БАЙГУУЛАМЖ" ТӨҮГ-ын ерөнхий
нягтлан бодогч



Б.Дэлгэрдалай

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"УАЗ МЕГА" ХХК-ИЙН ЗАХИРАЛ


Д.МЯГМАРСҮРЭН

 /Б.Дэлгэрдалай/

 /Д.Мягмарсүрэн/